


Солонгос, монгол хэлний үүсмэл үгсийг судлах нь

(Дүрслэх үгийн жишээн дээр)

Чимэддоржийн Дүүрэнжаргал 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Дорно дахины хэлний тэнхимийн багш, магистр, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2023-11-29

Засварласан - Revised:
2023-12-26

Хэвлэгдсэн - Published:
2023-12-26

duurenjargal@msue.edu.mn
ORCID: [0009-0005-4129-7474](https://orcid.org/0009-0005-4129-7474)



© 2023, Author(s)

Хураангуй: Солонгос, монгол хэлний авиа дуурайх, дүрслэх үгс нь нэн эртний уугуул үгс байх бөгөөд шинэ үг бүтэхэд чухал үүрэгтэй. Эдгээр үгсийн язгуурт үүсмэл үг бүтээх дагавар залган үйл үг, нэр үг, тэмдэг нэр бүтсэн байдаг. Тухайлбал, солонгос хэлний дүрслэх дан болон давтсан хэлбэрт “거리다[georida], 대다[daeda], 이다[ida]” зэрэг дагавар залган үйл үг, “하다[hada], -업[eob]” дагавар залгаж, тэмдэг үг, нэр үг бүтээх “-이[-i], -질[-jil], -쇠[soe], -아기, 어기[-agi,-eogi], -아지[-aji]” дагавар залган нэр үг бүтэж байна. Тэгвэл монгол хэлэнд дүрслэх язгуураас хэрхэн жинхэнэ нэр, үйл үг, тэмдэг нэр бүтэж буйг харьцуулан судлахыг зорилоо.

Түлхүүр үг: Дүр байдал, дагаврын арга, үг бүтэх ёс, жинхэнэ нэр, үйл үг, тэмдэг нэр

Удиртгал

Хүн төрөлхтөн байгаль ертөнцтэй салшгүй холбоотой аж төрөн амьдардгийн хувьд араатан, жигүүртэн, үзэгдэл, юмсын бараа дүр, дуу чимээг харж, сонсож, мэдэрч байдаг бөгөөд тэр бүхнийг хэлний дохиогоор тэмдэглэн илэрхийлсэн нь дүрслэх ба дуурайх үгс юм. Өөрөөр хэлбэл хүний чихээр сонссон дуу авиаг хэлэнд буулгасан нь авиа дуурайх үгс бол нүдээр харсан дүр байдлыг хэлэнд илэрхийлсэн нь дүрслэх үгс билээ.

Монгол хэлэнд дүрслэх язгуураас үүссэн үгс маш олон байх бөгөөд эдгээр үгс нь уугуул үгс байх тул эрдэмтэд монгол хэлний үгийн гарлыг тайлах чухал эх сурвалж бол дүрслэх, дуурайх үгс гэж үздэг. Монгол хэлний дүрслэх үгийн авианы сэлгэц, бүтэц, утгын талаар эрдэмтэн Г.Й.Рамстедт, Т.А.Бертагаев, Л.Ш.Шагдаров, Ц.Б.Цыдендамбаев, Ш.Лувсанвандан, Ц.Өнөрбаян, М.Базаррагчаа, Г.Гэндэнсүрэн, Ш.Нарантуяа зэрэг эрдэмтэд судалсан байна.

Солонгос хэлэнд дүрслэх үгийг 의태어(擬態語) гэх бөгөөд '의'(擬) нь баримжаалах, багцаалан бодох гэсэн утгатай бол '태'(態) хэлбэр, байдал '어'(語) нь үг, хэл гэсэн утгатай ханз үгс юм.

Солонгос хэлэнд дүрслэх үг хэрэглэгдэж эхэлсэн нь солонгос хэл анх үүссэн тэр үеэс боловч солонгос хэлний бичиг үсэг “Хүнминжөным” үүссэн үеэс тэмдэглэгдэж үлдсэн гэж үздэг байна. Гэвч бичиг үсэг үүссэн XIV зууны үеэс эхлээд дундад үеийн солонгос хэлний эх сурвалжид ховор байх ба XVIII зууны үеэс уран зохиолын эх сурвалжид түгээмэл тохиолдож эхэлсэн байна.

Эрдэмтэн Чай Уан *Солонгос хэлний авиа дуурайх ба дүрслэх үг* хэмээх бүтээлдээ авианы бэлгэдэх ёс (sound symbolism, phonetic symbolism) нь эгшиг, гийгүүлэгч тус тусдаа тогтсон утга илэрхийлэх бөгөөд тус авианы илэрхийлэх утгыг заана. Солонгос хэлэнд гийгүүлэгч, эгшиг нь сэлгэлтээсээ хамаараад бэлгэдлийн утга нь өөрчлөгддөг үгийн сангийн бүрдүүлбэрийн гол төлөөлөл бол авиа дуурайх, дүрслэх үг юм (2003: 76) гэжээ. Тиймээс ч дуурайх, дүрслэх үгийг нийтэд нь “бэлгэдлийн үг” гэж нэрлэж, авианы бэлгэдэх ёсны судалгааны гол хэрэглэгдэхүүн нь авиа дуурайх, дүрслэх үг болдог.

1. Солонгос хэлний дүрслэх язгуураас үүсмэл үг бүтэх нь

Орчин цагийн солонгос хэлний дуурайх, дүрслэх үгийг анх эгшиг, гийгүүлэгч авианы онцлогт нь тулгуурлан судалсан эрдэмтэн бол Жөнг Ин Сынг (1938) юм. Түүний дараа И Хый Сынг (1955), И Сүнг Ниөнг (1954 оноос хойш олон эрдэм шинжилгээний өгүүлүүд бичсэн), Нам Пүнг Хиөнг (1965) зэрэг эрдэмтэд үргэлжлүүлэн судалжээ. Эрдэмтэн Сун Мүн Жүн (1988), У Ин Хие (1990), Нома Хидэки (1991) нар авиа дуурайх үг, дүрслэх үгийн хэрэглэгдэхүүн, нийтлэг үндэслэл, уялдаа холбоог нарийвчлан судалсан байдаг.

Мөн Ян Хай Шиг *Орчин цагийн солонгос хэлний бэлгэдлийн үгийн судалгаа* (1973) сэдвээр, Ким Хунг Бөм *Солонгос хэлний бэлгэдлийн үгийн судалгаа* (1994) хэмээх сэдвээр, Ким Ин Хуа *Орчин цагийн солонгос хэлний авианы бэлгэдэх ёсны судалгаа* (1995) сэдвээр, Шин Жүнг Жин *Орчин цагийн солонгос хэлний авиа дуурайх үг ба дүрслэх үгийн судалгаа* (1998) сэдвээр тус тус докторын зэрэг хамгаалсан байна. Эрдэмтэн Нам Пүнг Хиөнг *Эгшиг авианы бэлгэдэл ба хэлний хөгжлийн тухай судалгаа* (1969), Дирек Хиндиллинк *Koreaniseche onomatopoeie* (1985), Баг Чанг Үөн *Орчин цагийн солонгос хэлний авиа дуурайх үг ба дүрслэх үгийн хэлбэр, авиа судлал* (1993), Юн Хый Үөн *Авиа дуурайх үг, дүрслэх үгийн ухагдахуун ба тодорхойлолт* (1993), И Сүнг Ниөнг *Авиа бэлгэдэх ёсны онол* (1954, 1958), Чуй Ху Чөл *Орчин цагийн солонгос хэлний бэлгэдлийн үгийн талаарх судалгаа* (1985), Ким Жүнг Сөб *Солонгос хэл суралцагчдад зориулсан авиа дуурайх үг, дүрслэх үгийг сурах аргын судалгаа* (2001) гэх мэт олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт зохиолууд

хэвлүүлсэн байна. Энэ сэдвээр нэлээд олон бүтээл туурвисан хүн бол эрдэмтэн Чай Уан бөгөөд тэрээр 1987 онд *Солонгос хэлний авианы бэлгэдэх ёсны хэдэн асуудал*, 1993 онд *Авиа дуурайх үг, дүрслэх үгийн хэлзүйн утга*, 2003 онд *Солонгос хэлний авиа дуурайх үг ба дүрслэх үг* хэмээх бүтээлээ хэвлүүлжээ.

Солонгос хэлний дүрслэх үгэнд дан бүтээврээс бүтсэн үг гэдэг нь ямар нэгэн дагавар аваагүй үндсээрээ байгаа үгс юм. Үүнд нэг үет, хоёр үет, гурван үет үгс байх бөгөөд цаашид утгат хэсэг болж задрахгүй, хамгийн бага бүтээврээс бүтсэн үгс юм. Жишээ нь: нэг үет үг: *씩, 확, 짝, 꼭*, нэг үет давтсан үг: *곰곰, 벌벌, 감감*, хоёр үет үг: *가웃, 훌떡, 미끈*, хоёр үет давтсан үг: *두근두근, 가뭏가뭏*, гурван үет үг: *가우똥, 방그레*, гурван үет давтсан үг: *간드랑간드랑, 몽기적몽기적* гэх мэт байна.

Солонгос хэлний дүрслэх язгуурт үүсмэл үг үүсгэх дагавар залган үүсмэл нэр үг, үйл үг, тэмдэг үг¹, бүтээсэн байна.

1.1. Дүрслэх язгуураас үүссэн нэр үг

Дүрслэх язгуурт үүсмэл нэр үг үүсгэх дагавар болох хүн, амьтан, юмсын нэрийг заах “-ㅇ[-i]”, үйл хөдлөлийг илэрхийлэх “-질[-jil]”, нэр үг бүтээх бүтээмж багатай дагавар болох “-ㅅ[soe], - 아기, 어기[-agi, eogi], -아지[-aji]” зэрэг дагавар залган нэр үг бүтсэн байна.

Жишээлбэл:

Хүснэгт 1. Солонгос хэлний дүрслэх язгуураас үүссэн нэр үг

Дүрслэх үг	Нэр үг
-ㅇ[-i] дагавар залгаж бүтсэн үг	
각둑각둑- бага зэрэг хатуу зүйлийг дөрвөлжин хэлбэртэй хэрчсэн байдал	각두기- цагаан манжингийн кимчи
죇둑죇둑- хоол хүнс зэрэг наалдамхай, зажлууртай байдал	죇둑이- цэлцэгнүүр
얼룩- 1. суурь өнгөнд өөр өнгийн цэг буюу судал холилдсон ор 2. шингэн зүйл наалдах буюу уусан үлдсэн ор	얼루기- алаг, эрээн, цоохор амьтан

¹ Солонгос хэлэнд тэмдэг үг нь үйлийн бүлэгт хамаарч, хувилдаг үгс байдаг тул тэмдэг нэр бус тэмдэг үг гэж нэрлэсэн болно.

결렁결렁- үг яриа, үйлдэл хөнгөн хуумгай байдал	결렁이- сагсуу, хөнгөн хуумгай хүн
똥똥- 1. ухаантай, сэргэлэн байдал 2. хатуу чанга, бат бөх байдал	똥똥이- сэргэлэн адтай хүүхэд
-질[-jil] дагавар залгаж бүтсэн үг	
속닥속닥- бусдад ойлгодохооргүй аярхан дуугаар байн байн ярих чимээ, байдал	속닥질- шивнээ яриа
-쇠[soe] дагавар залгаж бүтсэн үг	
덜렁- амгалан тайван бус ихэд хуумгай, хөнгөмсөг хандах байдал	덜렁쇠- яаруу сандруу хүн
-아기, 어기[-agi, -eogi] дагавар залгаж бүтсэн үг	
꺼끌꺼끌- гадаргуу нь хуурай, ширүүн байдал	꺼끄러기- тутарга, арвай зэргийн сахал, үзүүрийн нарийн үс
-아지[-aji] дагавар залгаж бүтсэн үг	
미끌미끌- гадна тал маш гөлгөр байдал	미꾸라지- чимхүүр загас

Бид солонгосын үндэсний хэлний хүрээлэнгээс эрхлэн гаргасан *Солонгос хэлний тайлбар толь бичиг* (160000 толгой үгтэй VI хэвлэл, 2008)-ээс дүрслэх язгуураас нэр үг бүтээх дээрх дагавруудаар бүтсэн үүсмэл нэр үгсийг түүн судалж үзэхэд “이[-i]” дагавар залгаж бүтсэн хүн, амьтан, юмсын шинж чанар, дүр төрхийг заан нэрлэсэн 65 нэр үг, “-질[-jil]” дагавар залган үйл хөдлөлийн нэрийг илэрхийлсэн 10 нэр үг, “-쇠[soe]” дагавартай 6 үг, “-아기, 어기[-agi, eogi]” дагавартай 13 үг, “-아지[-aji]” дагавартай 5 үг байна. Солонгос хэлэнд авиа дуурайх язгуураас дээрх дагавруудаар бүтсэн нэр үгс нэлээд ажиглагдаж байлаа.

1.2. Дүрслэх язгуураас үүссэн үйл үг

Солонгос хэлний дүрслэх үгэнд “-거리다[georida] (хөдөлгөөн, дуу авиа зэрэг тасралтгүй үргэлжлэх утгат дагавар)”, “-대다[daeda] (-거리다[georida]-тай ижил утгатай)”, “-이다[ida] (үйл хөдлөл, байдлыг илэрхийлэх язгуурт залгаж үйл үг бүтээх)”

дагавар залган үйл үг бүтээдэг. Ингэж бүтсэн үйл үг маш их. Дүрслэх үндэснээс бүтсэн үүсмэл үйл үгийн жишээг дагавар тус бүрээр үзүүлбэл:

Хүснэгт 2. Солонгос хэлний дүрслэх язгуураас үүссэн үйл үг

Дүрслэх үг	Үйл үг
-거리다[georida] дагавар залгаж бүтсэн үгс	
글썩-Нулимс хэзээ мөдгүй дусах дөхөн бялхан дүүрсэн байдал	글썩거리다-Цийлэгнэх, мэлтэлзэх
가웃- Толгой, биеэ нэг тийш хазайлгасан байдал	가웃거리다- хазайлгах, хэвийлгэх, гилжигнүүлэх
두리번- нүдээ томруулан эргэн тойрноо эргүүлж тойруулан харах байдал	두리번거리다- хялалзах, хялбалзах, ийш тийш харах
후들- гар, хөл, бие байн байн ихээр чичрэх байдал	후들거리다- салганах, чичрэх
끈적- 1. Зууралдан наалдах хэлбэр 2. харц, хандлага нь таагүй хатуу байх байдал	끈적거리다- наалдах, зууралдах, нялуурах, найланхайтах
-대다[daeda] дагавар залгаж бүтсэн үг	
달달- 1. даарч эсвэл айснаас тасралтгүй чичрэх байдал 2. Жижиг дугуй зүйл хатуу газар өнхөрч хөдлөх чимээ, байдал	달달대다-дагжих, чичрэх, салганах, бөн бөн хийх
울렁- 1. Ихэд цочих буюу айснаас зүрх байн байн цохилох байдал 2. Дотор эвгүйрэх байдал 3. Давалгаалах байдал	울렁대다-зүрх дэлсэх, дотор муухайрах, цалгих, давалгаалах, хотолзох, тахилзах

우쭈- 1. далайцтай нэг удаа хөдлөх байдал 2. өөртөө итгэлтэйгээр бардах байдал	우쭈대다- гунхах, найгах, онгирох, сагсуурах, сагах
소곤- бусдад ойлгогдохооргүй аяархан дуугаар тасралтгүй ярих чимээ, байдал	소곤대다-шивнэлдэх
덤빙-буурьтай биш хөөрцөглөн яарах буюу хамаа замбараагүй дайрах	덤빙대다- хөнгөмсөг загнах, хуумгай хандах
-이다[ida] дагавар залгаж бүтсэн үг	
펠릭-өргөн, том даавуу зэрэг салхинд хурдан, хүчтэй хөдлөх чимээ, байдал	펠릭이다-дэрвэгнэх, салбаганах
출랑-1. ус мэтийн зүйл байн байн зөөлөн давалгаалан хөдлөх байдал 2. анхаарал болгоомжгүй, хөнгөн хуумгай зан байн байн гаргах байдал	출랑이다-цалгилах, далдганах, сагсганах
흘쩍- 1. шингэн зүйлийг нэг дор ихээр залгилах, уух чимээ, байдал 2. нусаа бага зэрэг татах чимээ, байдал 3. нэг удаад хөнгөн гүйх ба нисэх байдал	흘쩍이다-мэгшин уйлах, нусаа татах, гүдхийн залгих
꺾떡-1. тод гэрэл байн байн асаж унтрах байдал 2. том нүдээ байн байн анивчих байдал	꺾떡이다- асч унтрах, асааж унтраах, улалзах, анивчих, тормолзох, анивалзах
글썽-нулимс хэзээ мөдгүй дусах дөхөн бялхан дүүрсэн байдал	글썽이다-цийлэгнэх, мэлтэлзэх

Эрдэмтэн Чай Уан *Солонгос хэлний авиа дуурайх ба дүрслэх үг* бүтээлдээ “-하다[hada], -거리다[georida], -대다[daeda]” зэрэг дагавар нь дан хэлбэртэй, давтсан хэлбэртэй дүрслэх үгэнд хоёуланд нь залгагдаж үүсмэл үйл үг бүтээдэг бол “-이다[ida]” дагавар нь зөвхөн дан хэлбэртэй дүрслэх язгуурт залгагддагаараа

онцлогтой гэжээ. Бид дээрх дагавруудаар бүтсэн үүсмэл үйл үгсийг *Солонгос хэлний тайлбар толь бичиг*-ээс судалж үзэхэд “-하다[hada]” дагавар залгаж бүтсэн үгс бүгд үйл үг бус “(형) тэмдэг үг” тэмдэглэгээтэй байсан нь сонирхол татаж байна. Солонгос хэлний дүрслэх язгуурт “-거리다[georida]” дагавар залгаж бүтсэн 810 үйл үг, “-대다[daeda]” дагавар 802 үйл үг байсан ба “-이다[ida]” дагавар залгаж бүтсэн үг харьцангуй цөөн буюу 77 үйл үг байна.

1.3. Дүрслэх язгуураас үүссэн тэмдэг үг

Солонгос хэлний дүрслэх үгэнд “-하다[hada]” дагавар залган үүссэн тэмдэг үг олон байна. Түүнчлэн “-르” гийгүүлэгчээр төгсөж буй язгуурт тэмдэг үг үүсгэх дагавар “-읍[eob]” -г залгаж тэмдэг үг бүтсэн жишээ бас байна. Тухайлбал,

Хүснэгт 3. *Солонгос хэлний дүрслэх язгуураас үүссэн тэмдэг үг*

Дүрслэх үг	Тэмдэг үг
-하다[hada] дагавар залгаж бүтсэн үг	
동글동글- олон янзын зүйл бүгд дугуй хэлбэртэй байх байдал	동글동글하다- дугуй, дугариг, бөөрөнхий байх
물컹- бутрах шахам энд тэнд бамбалзсан мэдрэмж	물컹하다- зөөлхөн, нялцгардуу байх
매끈- овойж товойсон зүйлгүй тэгшхэн байдал	매끈하다- тэгшхэн, толигор, гөлгөр, гоолиг, шулуун, өө сэвгүй байх
탱탱- 1. таргалсан юмуу хөөн чангарсан байдал 2. маш хатуу, бат бөх байдал	탱탱하다- цүндийх, бэмбийх, бондойх, чангарах, хатуурах
하늘하늘- 1. сулхан зөөлөн зөөлөн хөдлөх байдал 2. хатуу эд зөөлрөн барьцгүй болох 3. ямар нэг зүйлд баригдалгүй чөлөөтэй тоглон наадах байдал	하늘하늘하다-намилзах, намирах, нялцгардуу байх

4. уур, утаа, зэрэглээ зэрэг бага багаар үргэлжлэн гарч ирэх байдал	
-업[eob] дагавар залгаж бүтсэн үг	
간질간질- 1. байн байн ирвэгнэх мэдрэмж, төрх байдал 2. ямар нэг зүйлийг тэвчиж байхын аргагүй хүсэх байдал	간지럽다- ирвэгнэх, загатнах, ичгэвтэр
시끌시끌- маш их чимээ шуугиантай байдал	시끄럽다- шуугиантай, дуу чимээ ихтэй байх, хэл ам гарах, шуугих
어질어질- ухаан санаа бүүр түүр болон толгой эргэх мэдрэмж	어지럽다-эргэх, эрээлжлэх, будилах, самуурах, түгшүүртэй, тогтворгүй, эмх замбараагүй, бодлогогүй, хөглөрсөн, ундуй сундуй байх
보들보들-зөөлөн арьстай, булбарай байдал	보드럽다- булбарай, зөөлөн, уян зөөлөн, халуун дулаан, нарийн ширхэгтэй, нунтаг зөөлөн байх
미끌미끌- маш их халтиргаатай байдал	미끄럽다 ² -халтиргаатай байх

Солонгос хэлний тайлбар толь бичиг бүтээлд “-하다[hada]” дагавар залгаж бүтсэн 766 тэмдэг үг, “-업[eob]” дагавар залгаж бүтсэн 148 тэмдэг үг байна. Дүрслэх үгийн язгуурт –“하다[hada]” дагавар залган тэмдэг үг үүсгэдэг бол авиа дуурайх үгэнд залгаж тэмдэг үг үүссэн нь бараг байхгүй байгаа нь сонирхол татаж байна.

2. Монгол хэлний дүрслэх язгуураас үүсмэл үг бүтэх нь

Эрдэмтэн Л.Ш.Шагдаров “Юмсыг нүдээр харж, түүний гадаад дүр төрхийн тухай бүрэн төсөөлж чадахуйц үгсийг дүрслэх үг гэж ухаарч болно” (Базаррагчаа, 2011: 26 дам эшлэв) хэмээн тодорхойлж, дүрслэх үгийн 4 онцлогийг дурдсан бол эрдэмтэн М.Базаррагчаа *Монгол хэлний дүрс дуурайх үг* бүтээлдээ дүрслэх үгийн тодорхойлолт, авианы сэлгэц, бүтэц бүтээврүүдийн тухай тодорхой дурджээ

² -업[eob] дагавар залгаж бүтсэн үгсийн хэлбэр толь бичигт хэрэглэгдэж байгаа буюу солонгос хэлний төв аялгуунд “립” байна. Энэ нь “Солонгос хэлний дуудах зүйн дүрэм” (1993), “Солонгос хэлний зөв бичих дүрэм” (1988)-д заасан дэвсгэр үгсийн дүрэмтэй холбоотой.

(Базаррагчаа, 2011: 26). Эрдэмтэн Ц.Өнөрбаян *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс* бүтээлдээ “Гадаад байдал дүрслэх язгуурын бүтцэд орж байгаа авиа бүрд хүн амьтан, юмс үзэгдлийн гадаад төрх байдал, хөдөлгөөний янз бүрийн ялгамжийг илрүүлэх үүрэг байдаг” (Өнөрбаян, 2000: 90) гээд монгол хэлний дүрслэх үгийн эгшиг, гийгүүлэгч авианы илэрхийлэх утга, авианы сэлгэлтийн талаас “Монгол хэлний гадаад байдал дүрслэх язгуурын хэлний тогтолцоонд гүйцэтгэх нэг чухал үүрэг бол үг бүтээх дагавар авч хэлний үгийн санг баяжуулах шинж мөн” (Өнөрбаян, 2000: 100) гээд дүрслэх чөлөөт биш язгуураас үйл үг бүтээх дагавар тус бүрийг утга, хэрэглээний талаас нарийн судалжээ. Бид монгол хэлний дүрслэх язгуураас бүтэх үүсмэл жинхэнэ нэр, үйл үг, тэмдэг нэрийг судлахдаа Ш.Нарантуяа *Дүрслэх үгийн тайлбар толь бичиг* бүтээлийг судалгааны хэрэглэгдэхүүн болгосон болно.

2.1. Дүрслэх язгуураас үүссэн жинхэнэ нэр

Монгол хэлний дүрслэх язгуураас үүссэн жинхэнэ нэрийн тухайд эрдэмтэн Г.Й.Рамстедт “ai” төгсгөлтэй монгол үгсийн дунд хэзээ нэгэн цагт ийм байсан эсвэл дагавар болсон буюу хоёрдогч үүсмэл бүтээвэр дайралддаг. “-yai, -qai” төгсгөлтэй үйлээс үүссэн нэрийн хажуугаар мөн төгсгөлтэй нэрээс нэрийн зүйл олонтоо байдаг. Гэвч эдгээрээс нэр ба үйл аль нь анхдагч болохыг тухайн тохиолдолд ялгахад хэцүү юм³ гэжээ.

Эрдэмтэн М.Базаррагчаа (doli-уї) долиых гэдгийн “-yi” нь “-ya”-аас үүсэж “i” нь “a”-тай сэлгэж, улмаар “i” нь “y/g” гийгүүлэгчийг “-yi” болгосон бөгөөд энэхүү “-yi” үе утгалбар нь арвайх-арвай, тарнайх-тарнай(мод) зэрэг үгс болсон гээд сарнайх-сарнай (цэцэг), сагнайх-сагнай (морины хөхөл), бамбайх-бамбай (хуяг бамбай), тавхайх-тавхай (хөлийн тавхай), хамхайх-хамхай (зэрлэг гахай), умайх-умай (эхийн сав), сагсайх-сагсай (агшаасан будаа), бэмбийх-бэмбий (хэвийн боовны гурил), нэлхийх-нэлхий (өлгий), мэлмийх-мэлмий, шорнойх-шорной (ургамлын нэр), цоройх-цорой (өвчүүний хормой), одойх-одой зэрэг үгсийг дурджээ. Түүнчлэн “-l...” (дээрээс доошлох, дахин давтах утгатай), “-ja” (дороос дээшлэх утгатай) дагаврууд нийлж “уг юм дээшлэх, доошлох зэргээр хөдөлж, ахин давтаж үргэлжлэх” утга бүхий хэлц бүтээвэр болсон гээд шалз, угалз, хувалж, гурвалж, улаалж, шарилж, эрвээлж, гүрвэлж зэрэг жишээг дурджээ. “-lja дагаврын дараа “онцлон ялгах утга бүхий” “-ya”, “доошлон намжих утга бүхий” “-na” дагавраас бүтсэн “-yana” гэсэн хэлц дагаврыг залгаж улаалзгана, агилзгана, гүзээлзгэнэ, хүрэлзгэнэ зэрэг, “-yana” дагавар нь үйл үг бүтээхээс гадна мөн нэр үг бүтээнэ гээд азаргана, хялгана, бударгана, улаагана, гөлтгөнө зэрэг жишээг дурджээ (Базаррагчаа, 2011: 29-34).

Орчин цагийн монгол хэл II бүтээлд идэвхгүй язгуураас нэр үг бүтээх дагавар “-aa (-ээ, -оо, -өө)”: овоо, гүвээ, цагаа, улаа зэрэг, “-n”: оvon, товон, “-na (-нэ, -но, -нө)”:

³ 케이 램스테트. 알타이어 형태론 개설. 1952. 216 페이지

гуна, дөнө дагаврууд байна гэжээ. Харин дээр дурдсан “-лзгана”, “-лж” дагаврыг нэр язгуур, үндэснээс жинхэнэ нэр бүтээх дагаварт оруулсан ба “-аан” (-ээн, -оон, -өөн) дагаврыг үйл язгуур, үндэснээс жинхэнэ нэр бүтээх дагавар гэж үзжээ. (2020: 25-26)

Ш.Нарантуяа *Дүрслэх үгийн тайлбар толь* бүтээлд аазгай, болхонцог, бөмбөлөг, орилоон, цуурай, чичиргээ гэсэн цөөн тооны жинхэнэ нэр багтжээ.

Иймд монгол хэлэнд дүрслэх язгуураас үүссэн жинхэнэ нэр үгсийг гүнзгийрүүлэн судлахын тулд үгийн гарлын талаас хөөн судлах шаардлага тулгарч байна.

2.2. Дүрслэх язгуураас үүссэн үйл үг

Монгол хэлэнд дүрслэх язгуураас үйл үг бүтээх “-үана-”(хоромхон огцом давтагдах), “-s ki-”(хоромхон огцом эрчимтэй болох), “-lj-”(хүн, юмсын давтагдах хөдөлгөөн), “-yi-”(нэг удаа үргэлжлэн болох), “-gi, -ki, -ge-” (хэсэг онцгой болох), “-r” (салах, холдох, эвдрэх)” гэсэн дагаврууд байна. Уг дагавруудаар бүтсэн үүсмэл үйл үгсийг түүн судалж дагавар тус бүрээр ангилж үзвэл,

а. “-үана-” дагавар залгаж бүтсэн үйл үг

Эрдэмтэн Ц.Өнөрбаян *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс* бүтээлдээ дүрслэх чөлөөт биш язгуураас хоромхон давтагдах утгатай *-гана-* дагавар нь *-гана-*, *-гэнэ-*, *-гоно-*, *-гөнө-* гэсэн дөрвөн хувилбартай бөгөөд эдгээрийг эгшиг зохицуулан залгана (2000:111) гэжээ. Эрдэмтэн М.Базаррагчаа *Монгол хэлний дүрс дуурайх үг* бүтээлдээ “энэ *-үана...* дагавар нь үйл үг бүтээхээс гадна жинхэнэ нэр бүтээж болно” гээд харгана, гүзээлзгэнэ, долоогоно, гөлтгөнө, зээргэнэ, хэдгэнэ зэрэг үгсийг жишээ болгон дурдаад эдгээр үгс нь хамар, чихнээ сэрэгдэх үнэр, дуунаас үүдэлтэй (2011:30) гэжээ.

Ш.Нарантуяа *Монгол хэлний дүрслэх үгийн тайлбар толь* бүтээлд арваганах, арзганах, бавганах, балтганах, бараагнах, бөгтгөнөх, бөгтгөнөх, бөмбөгнөх, жайвганах, жайжганах, жирвэгэнэх, жооргонох, ирвэгэнэх, лаглаганах, лундганах, майжганах, мөлийх, муриганах, мэлтгэнэх, начигнах, нижигнэх, овгонох, оодгонох, ондгонох, өндөгөнөх, цулцганах, цүзгэнэх, чичгэнэх, эрвэгэнэх, язганах, янгинах... гэх мэт үгс байна.

б. “-s ki-” дагавар залгаж бүтсэн үг

Эрдэмтэн Ц.Өнөрбаян “-схий дагавар нь бүтээлч *-схий*, бүтээлч биш *-вхий* гэсэн хоёр хувилбартай гээд үйл үндсэнд чөлөөт биш язгуураас үйл үг бүтээх дагавар *-схий* нь орохгүй. Тухайлбал, *сартай-*, *дэрдий-*, *годой-* гэсэн үүсмэл үйл үндсэнд залгаж буй *-схий* нь үйлийн эрчимтэй болохыг зааж байгаа хэл зүйн утгатай нөхцөл бол *сарт-*, *дэгд-*, *год-*, *тонго-* гэсэн чөлөөт биш язгуурт залгаж буй *-схий* бол үг бүтээх дагавар

(2000:104) гэж үзжээ. Эрдэмтэн М.Базаррагчаа *сэрд хийх, под хийх, ирвэс хийх, гэхээс хийх* зэрэг үгсийн “хийх” гэдэг үгийг салгаж бичвэл зохилтой. Энэ нь хоромхон үйлдэх болцын *-skī, -bkī* дагавартай гарал нэг боловч ялгаатай юм (2011: 31) гэжээ.

“-s ki-” дагавар орсон үгсийг дурдвал, *бултас хийх, ганхас хийх, гүвс хийх, гүрдэс хийх, гэдэс хийх, гялс хийх, гялтас хийх, дав хийх, далбис хийх, дүрс хийх, дэгдгэс хийх, дэндгэс хийх, зарс хийх, займс хийх, зурс хийх, зэрс хийх, манас хийх, мохис хийх, мухас хийх, мэлэс хийх, мэхэс хийх, найгас хийх, намс хийх, нахис хийх, нилс хийх, нэл хийх, нэвсгэс хийх, овс хийх, өлс хийх, өндөс хийх, чичирс хийх, чорвос хийх, ширвэс хийх, шовс хийх, эрвэс хийх, ярвайс хийх, ярс хийх...* гэх мэт үгс байна.

с. “-lǰ-” дагавар залгаж бүтсэн үйл үг

Г.Й.Рамстедт монгол хэлний *-лжа* дагавар нь түүхэн үүднээс *-л-жа* гэсэн нийлмэл бүтэцтэй бөгөөд *-га-лжа, -ба-лжа* гэсэн нийлмэл бүтэц тохиолддогийг төрөл хэлний үзэгдэлтэй харьцуулан тайлбарласан байна. Эрдэмтэн Ц.Өнөрбаян үйл үг, нэр үг, тэмдэг нэр зэргээс үйл үг бүтээх *-лз* дагавар монгол хэлэнд байхгүй тул *-лз* дагавар нь чөлөөт биш дүрслэх язгуураас үйл бүтээх дагавар юм (2000: 107) гэж үзсэн байна. Эрдэмтэн М.Базаррагчаа *-l-ja* дагавар нь хоёр үе-утгалбараас бүтэж “юмсын дээшлэх доошлох зэргээр хөдөлж, дахин давтаж үргэлжлэх” утга бүхий хэлц бүтээвэр болно. Уг дагавар нэр болон хөрвөж, *шалз, угалз, гурвалж, авхаалж, сараалж, эрвээлж, тэрэлж* зэрэг амьтан ургамал болон юмсын дүрсэд давтагдсан тоо зэргийн байн байн хөдлөх утга бүхий жинхэнэ нэр бүтээсэн (2011: 29) гэж үзжээ.

-lǰ дагавар залгаж бүтсэн үгсийн жишээг дурдвал, *ангалзах, арзалзах, ативалзах, бамбалзах, тарвалзах, боролзох, бөөвөлзөх, бөгтөлзөх, бөлбөлзөх, бөлтөлзөх, бөртөлзөх, мурилзах, мушилзах, мэлмэлзэх, мэлтэлзэх, мэхэлзэх, мяралзах, навталзах, намбалзах, намалзах, намилзах, нугсалзах, оволзох, олилзох, өлбөлзөх, өлөлзөх, өмөлзөх, өндөлзөх, өрвөлзөх, саахалзах, савалзах, сагсалзах, сарвалзах, сарталзах, сархалзах, солбилзөх, сортолзох, соохолзох, сөлөлзөх, сөрвөлзөх, цайвалзах, цийлэлзэх, шилбэлзэх, шоволзох, шоохолзох, шумбалзах, эрвэлзэх, яйвалзах, яралзах ...*зэрэг үг байна.

d. “-yi-” дагавар залгаж бүтсэн үг

Эрдэмтэн М.Базаррагчаа дүрслэх үйл үгийн “байнга үргэлжлэх” утга бүхий *-yi* бүтээвэр нь хийх, гэх, хэмээх үйл үгээс улиран хувьссаар байдал заасан утгат дагавар болсон (2011: 33) гэж үзсэн бол эрдэмтэн Ц.Өнөрбаян монгол хэлний гадаад байдал дүрслэх язгуураас үйл үг бүтээх *-ай* дагавар нь *-ай, -ий, -ой* гэсэн хувилбартай бөгөөд үйлийн нэг удаа үргэлжлэн болох болц байдлыг заасан үл тусах үйл үг бүтээдэг бүтээлч дагавар юм (2000: 102) гэжээ. *-yi* дагавар залгаж бүтсэн үйл үгсийн жишээг дурдвал, *алхайх, арсайх, марсайх, архайх, дархайх, сархайх, багсайх, бамбайх, бандайх, балтайх, барайх, торойх, баржайх, богцойх, божийх, болцойх, бонхойх,*

бөөвийх, бөгтийх, бөөдийх, бөмбийх, бөндийх, бөнжийх, гүлдийх, гялтайх, гянайх, далбайх, далжийх, дарвайх, дарайх, домбойх, донхойх, дөмбийх, дурайх, духайх, дүмбийх, дүндийх, дүрсийх, дүрлийх, дүхийх, дүүхийх, дэгдийх, дэглийх, дэндийх, дэнхийх, дэрвийх, дэрийх, дээхийх, ёрдойх, ёлтойх, ёнхойх, ёрдойх, жайвийх, , сархайх, сортойх, сөглийх, хүгдийх, хүглийх, хэлбийх, хэрзийх, хэлхийх, хялайх, хяртайх, цавцайх, цайлалзах, цийх, цогнойх, цодойх, цойлох, цонхийх, цорвойх ... гэх мэт үг байна.

-gi, -ki, -ge дагавар залгаж бүтсэн үйл үгсийн тухайд эрдэмтэн М.Базаррагчаа *шаргих, шуугих, баагих, боргил, аргил* зэрэг үгсийн *-gi* дагавар нь *-ki, -ge* үйл үгээс үүсэлтэй дагавар гэж үзжээ. *-gi, -ki, -ge* дагавар нь хэсэг онцгой гэсэн хийсвэр утгатай болно. Эдгээр дагавраас бүтсэн үгсийг дурдвал, *аахилах, баагих, булгилах, бургилах, долгилох, дүүгэх, дэргэх, ёргих, мушгих, нуугих, нүүгэх, саагих, тургих, паргих, нургих, уухилах, харгилах, хүүгэх, цалгих, царгих, яргих* гэсэн үгс байна.

Харин *-r* дагавар залгаж бүтсэн үйл үгсийн хувьд эрдэмтэн Ц.Өнөрбаян дүрслэх язгуурыг үйл байдлыг дүрслэх язгуур, гадаад байдал дүрслэх язгуур гэж ангилж үзээд үйл байдал дүрслэх язгуур нь тооны хувьд цөөн бөгөөд *-л, -р, -ч* гэсэн 3 дагаврын өмнө орж үйл үг бүтээнэ гэж үзсэн байна.

Тухайлбал, *-л*

Тас+ *-р*

-ч дагавруудыг бүгдийг залгаж болж байна.

Эрдэмтэн У-Ж.Ш.Дондуков дайвар үгэнд *-р* дагавар залгаж үйл үг бүтэхдээ хэсэг хэсэг болгох, салах, холдох, гадагшлах, хажуу тийш хөдлөх, нэвтлэх, эвдрэх зэрэг утга илтгэнэ гээд *хэмхэр, ховхор, халбар, нэвтэр, бяцар, мултар* зэрэг жишээг дурджээ. Ш.Нарантуяа *Монгол хэлний дүрслэх үгийн тайлбар толь* бүтээлд *-л, -ч* дагавар авсан үгс байхгүй, харин *-р* дагавар авч үйл үг болсон үгс цөөн тоотой байв. Тухайлбал, *алмайрах, асгарах, атирах, багирах, бадайрах, ботгирах, бөөгнөрөх, бөмбөрөх, гөлрөх, дунгуйрах, манарах, мэлмэрэх, мэлтрэх, мэнэрэх, намирах, нумрах, нэвсрэх, зэвхийрэх, орхирах, тонгорох, нэлмэрэх, овоорох, өлбөрөх, өнхрөх, тунарах, уймрах, унжрах, уухирах, улайрах, хамхрах, хомхойрох, хөлбөрөх, хөхрөх, хуйлрах, хяхрах, цайрах, цацрах, цурхирах, чичрэх, чинэрэх, шогширох, эвхрэх* зэрэг үгс байна. Эдгээр үгсийг ажиглахад *-р* дагавар авч байгаа үгс *-ч, -л* дагавруудыг залгаж болохгүй үгс байгаа нь сонирхолтой байна.

Ш.Нарантуяа *Дүрслэх үгийн тайлбар толь* бүтээл дэх дүрслэх язгуураас бүтсэн үйл үгсийг дагавар тус бүрээр ангилан үзүүлбэл,

Хүснэгт 4. *Монгол хэлний дүрслэх язгуураас үүссэн үйл үг*

-yana-	-s ki-	-lj-	-yi-	-gi, -ki-, -ge-	-r-	Нийт
80 үг	72 үг	150 үг	259 үг	21 үг	43 үг	625 үйл үг

Дээрх хүснэгтээс үзэхэд дүрслэх язгуураас үйл үг бүтээх бүтээмж өндөр хэрэглэгдэх дагаврууд нь “-yi-”, “-lj-” болох нь харагдаж байна.

2.3. Дүрслэх язгуураас үүссэн тэмдэг нэр

Орчин цагийн монгол хэлэнд дүрслэх язгуураас үүссэн тэмдэг нэр нэлээд байх бөгөөд *-yar* дагавар залгаж бүтсэн тэмдэг нэрийн хувьд эрдэмтэн М.Базаррагчаа дүрслэх үйл үгийн “байнга үргэлжлэх” утга бүхий *-yi* бүтээвэр нь *ki-*(хийх), *ge-*(гэх), *ke-mē-*(хэмээх), тусах үйл үгээс сэлгэж үүссэн *-gi, gir, yar, ger, güir* дагавар болж, *годгор, унжгар, урвагар, майжгар, гялгар, хорчгор, дорсгор, өрвөгөр, цэлгэр* хэмээх хэлбэр дүрс заасан утгатай тэмдэг нэр бүтээжээ (2011: 21). *-yar* дагавар залгаж бүтсэн тэмдэг нэр монгол хэлэнд маш түгээмэл тохиолдох бөгөөд *-гар, -гэр, -гор, -гөр* гэсэн хувилбаруудтай байна. Тухайлбал, *арсгар, архгар, атигар, бавгар, бамбагар, бандгар, бөөвгөр, барзгар, барвагар, баржгар, сарзгар, баргар, болцгор, бондгор, борвогор, бөөвгөр, бөгцгөр, бөлцгөр, бөмбөгөр, бөндгөр, бумбагар, дүнсгэр, дүнхгэр, дүрлэгэр, сэгсгэр, сэвгэр, сэрвэгэр, тагдгар, тагжгар, цулцгар, цүдгэр, цүндгэр, цэлхгэр, чорчгор, чөргөр, шантгар, шонтгор, шөвгөр, шөмбөгөр, эрвэгэр, ээтгэр, ялбигар, ямбигар, янхигар, ярзгар...* гэх мэт байна.

Ш.Нарантуяа Монгол хэлний дүрслэх үгийн тайлбар толь бүтээлд дээрх идэвхтэй хэрэглэгдэх дагавар *-yar* дагавраас гадна *-lj+uug, -yana+uug* бүтэцтэй тэмдэг нэр үүссэнийг харж болно. Тухайлбал, *алгуур, дэвэлзүүр, оволзуур, соохолзуур, сээхэлзүүр, хохилзуур, хөвөлзүүр, хөхөлзүүр, цоролзуур, цэхэлзүүр, хуйсгануур, хүнгэнүүр, паржигнуур, чичигнүүр, шалгануур, янишуур* зэрэг үгс, *-r* дагавар залгаж бүтсэн *ёнхор, мугалзар, оготор, халтар, ханхар, цахир, цоохор, цэнхэр* зэрэг *-yi, -ā, -ī:* бөөдий, бөгшөө, булбарай, гоомой, дүлий, дүмбий, жороо, майжгий, налуу, нахиу, ороо, орилоо, саруй, сөөлжүү, тагшаа, унжуу, паргиа, хөлчүү, хөхөлбий, цовоо, чарлаа зэрэг үгс, *-ngqāi (-ngkī): бөөрөнхий, гоожинхой, дүүрэнхий, сиймхий, сэтэрхий, татанхай, уранхай, хөөрөнхий, “qāi-”: бяцархай, мялархай, навсархай, налархай, ноорхой, онгорхой, тугдаахай, халирхай, хамхархай, ханзархай, хонхорхой, хувхай, цоорхой* зэрэг үгс, *-yāi: арзгай, хавтгай, халцгай, -kī: хөвөрхий, цөмөрхий, -n* дагавар залгаж бүтсэн *бөлцөн, бумбан, бүүдэн, доголон, дүүрэн, ёлтон, мэлтэн, сүмбэн, сээтэн, улцан, хомбон, хөөрхөн, хумбан, хялман, цийлэн, цэлдэн, чилдэн, ээтэн, ялбан*

зэрэг үгс, *-gin, -yan*⁴ бүгээн, гилбэгээн, намуун, тогтуун, хахарган, цэгээн, эрээн зэрэг *-g* дагавар залгаж бүтсэн гүжирмэг, дугариг, дүгрэг, мойног, паланцаг, пөөнөг, харлаг, хөхөмдөг, цомцог, цэвдэг, цэлмэг, шорвог, эрхэмсэг, эрэмдэг зэрэг тэмдэг нэр үгс байна.

Тэмдэг нэрийн тухайд

Хүснэгт 5. Монгол хэлний дүрслэх язгуураас үүссэн тэмдэг нэр

<i>-γar</i>	<i>-uur</i>	<i>-r-</i>	<i>-yi</i> (<i>-ā, -ū</i>)	<i>-ngqāi</i> (<i>-ngkī</i>)	<i>qāi-</i>	<i>-kī</i>	<i>-n</i>	<i>-gin, -yan</i>	<i>-g</i>	Нийт
166 үг	16 үг	8 үг	21 үг	8 үг	13 үг	2 үг	19 үг	7 үг	14 үг	274 тэмдэг нэр

Дүрслэх язгуураас тэмдэг нэр бүтээх бүтээмж өндөр дагавар бол *-γar* байна. Бусад дагаврын хувьд цөөн тоотой боловч дүрслэх язгуураас тэмдэг нэр үүсэхэд оролцож байна.

Монгол хэлэнд дүрслэх язгуураас үйл үг, тэмдэг нэр бүтээх дагаврууд нь өндөр бүтээмжтэй байгаа нь ажиглагдаж байна.

Дүгнэлт

Алтай язгуурын хэлний бүлэгт ихэнхдээ хамруулж үздэг солонгос хэл нь залгамал бүтэцтэй хэл бөгөөд үгийн сангийн тодорхой хувийг нь дүрслэх үг эзэлдэг. Утга зохиолын хэлэнд маш түгээмэл хэрэглэгдэх дүрслэх үгс олон өвөрмөц шинжийг өөртөө агуулж байх бөгөөд энэ удаад солонгос, монгол хэлний дүрслэх язгуураас үйл үг, тэмдэг нэр, нэр үгс хэрхэн үүсдэг тухай судалсан болно.

Монгол хэлний дүрслэх язгуураас үүссэн үгсийн тухайд Ш.Нарантуяа *Дүрслэх үгийн тайлбар толь* бүтээлийг хэрэглэгдэхүүн болгож, 625 үйл үг, 274 тэмдэг нэр, 6 жинхэнэ нэр үгсийг түүн тухайн үгс ямар дагавраар үүсмэл үг болж илэрч буйг судалж үзлээ. Харин солонгос хэлний тухайд үндэсний хэлний хүрээлэнгээс гаргасан *Солонгос хэлний тайлбар толь бичиг*-ээс дүрслэх язгуураас үүссэн 1689 үйл үг, 914 тэмдэг үг, 99 нэр үг байгааг түүж үзэн дагавар тус бүрээр ангилан харьцааг гаргасан болно.

⁴ Эрдэмтэн Г.Й.Рамстедт “-gi-” дагавар нь “-n” дагавартай нийлж “-gi-n” “-ya-n” дагавар болсон гэж үзжээ. 게이 램스테트. 알타이어 형태론 개설. 1952. 156 페이지

Монгол, солонгос хэлний дүрслэх язгуураас үүссэн үгсийн дунд үйл үг хамгийн их байх бөгөөд үүсмэл нэр үг бага байна. Монгол хэлэнд дүрслэх язгуураас үүссэн жинхэнэ нэр үгийг илрүүлэхэд үгийн бүтэц, гарлын талаас гүнзгийрүүлэн судлах шаардлага байгаа буюу дүрслэх язгуураас үйл үг, тэмдэг нэр бүтээх дагаврууд шиг тодорхой биш байна.

Солонгос хэлэнд дүрслэх үгс тодорхой байх бөгөөд түүн дээр залгаж үйл үг, тэмдэг үг, нэр үг бүтээх дагаврууд ч тодорхой байна. Гиймээс ч солонгос хэлний дүрслэх үгс үндсээрээ байхдаа дайвар үгийн айд хамаарч маш идэвхтэй хэрэглэгдэнэ. Үйл үг, тэмдэг үг, нэрийн дагавар авч үүссэн үгс тухай тухайн айдаа хамаарна. *Солонгос хэлний тайлбар толь бичиг*-т идэвхтэй хэрэглэгдэх 1275 дүрслэх дайвар үг гарч байна.

Харин монгол хэлэнд дүрслэх үгсийн бүтцийг судалж үзэхэд дүрслэх үгийн язгуур нь чөлөөт биш идэвхгүй байх бөгөөд үйл үг, тэмдэг нэр бүтээх дагавар авч байж сая идэвхтэй хэрэглэгдэж буй нь сонирхол татаж байна.

Солонгос хэлний дүрслэх язгуурт “-거리다[georida], -대다[daeda]” гэсэн ижил утгатай дагаврын аль алиныг залгаж үйл үг үүсгэж болно. “-이다[ida]” дагаврын харьцангуй цөөн язгуурт залгагдаж үйл үг үүсгэсэн байгаа нь энэ дагавар гагцхүү дан хэлбэртэй дүрслэх язгуурт залгагддагтай холбоотой. Харин үүсмэл тэмдэг үгийн тухайд дүрслэх үгийн язгуурт “하다[hada]” дагавар хамгийн их залгагдаж үүссэн байхад “-엮[eoB]” дагавартай үүсмэл үг цөөн байна. Энэ учир нь уг дагавар зөвхөн “ㄷ[r/l]” гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгагддаг байна. Үүсмэл нэр үг бүтээх “-이[-i]” дагавар залгаж бүтсэн үгс нь гол төлөв хүний гадаад төрх, зан чанарыг дүрсэлсэн үгс байна. Харин “-질[-jil], -죄[soe], -아기, 어기[-agi,-eogi], -아지[-aji]” дагаврууд бүтээмж маш бага дагаврууд болох нь ажиглагдлаа.

Монгол хэлний тухайд дүрслэх язгуурт залгаж үүсмэл үйл үг бүтээх *-yi, -lj, -yana* дагаврууд бүтээмж өндөр байхад *-s ki-, -gi, -ki, -ge, -r* дагаврууд бүтээмж харьцангуй бага байна. Үүсмэл тэмдэг нэрийн хувьд *-yar* дагавар хамгийн их үүрэгтэй байгаа бөгөөд *-uur, -r-, -yi (-ā, -ū), -ngqāi (-ngkī), qāi-, -kī, -n, -gin, -yan, -g* дагаврууд бүтээмж бага байгаа нь ажиглагдлаа.

Монгол хэлэнд сарвас хийх, сартас хийх, сархас хийх, сортос хийх, сэрвэс хийх, сэрдэс хийх, сэртэс хийх гэх зэргээр солонгос хэлэнд *달랑달랑[dallang dallang]-* *덜렁덜렁[deolleong deolleong], 가랑가랑[garang garang]-* *그렁그렁[guireong guireong],* *꿀각[ggulggag]-* *꿀꺽 [ggulgeog], 도란도란[du-ran du-ran]-* *두런두런[dureon dureon],* *뚜덕뚜덕[ddudeog ddudeog]-* *또닥또닥[ddudag ddudag]* зэргээр эгшиг, гийгүүлэгч авиа сэлгэж бүтсэн үгс маш олон ажээ.

Солонгос хэлний дүрслэх үгийг хэлбэрийн хувьд дан ба давтсан (ижил авиагаар давтсан, төстэй авиагаар давтсан) гэж ангилна. Дан хэлбэртэй үг нь тухайн шинж байдлын ганц тоог илэрхийлэх бөгөөд давтсан үг нь тухайн шинж байдлын олон тоог илэрхийлж байна.

Study of Korean and Mongolian Derived Words

(Using mimetic words as an example)

Duurenjargal Chimeddorj

Department of Oriental Languages, Mongolian National University of Education

Ulaanbaatar, Mongolia

Abstract: Korean is an agglutinative language belonging to the Altaic language. And there are many mimetic words in the vocabulary. Mimetic words, which are often used in literary works, have unique characteristics. In this paper, we will examine how verbs, adjectives, and nouns are formed from mimetic words stems in Korean and Mongolian.

As for the words derived from the mimetic stem of Mongolian, 625 verbs, 274 adjectives, and 6 nouns were studied by referring to Sh. Narantuya's *Explanatory dictionary of mimetic words* and the words derived from these words were studied. In the case of Korean, 1,689 verbs, 914 adjectives, and 99 nouns derived from mimetic words stems were classified according to suffixes in the *Korean explanatory dictionary* published by the National Institute of the Korean Language.

Among words formed from mimetic words stems in Mongolian and Korean, there are the most verbs and the fewest derived nouns. In order to find out nouns formed in mimetic stems in Mongolian, in-depth research on the structure and etymology of words is essential. Otherwise, it is not as clear as the result of the creation of verbs and adjectives in the mimetic stem.

Keywords: characterisation, suffixation, word formation, noun, verb, adjective

Ном зүй

- Базаррагчаа, М. (2011). *Монгол хэлний дүрс дуурайх үг*. Улаанбаатар.
Базаррагчаа, (1987). *Монгол хэлний авианы сэлгэх ёс*. Улаанбаатар.
Базаррагчаа, (1992). *Монгол үгийн гарлыг мөшигх нь I*. Улаанбаатар.
Бямбасан, П. (1975). *Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг*. Улаанбаатар.
Гэндэнсүрэн, Г. (1973). “Орчин цагийн монгол хэлний дүр байдал заасан үгийн тухайд.” *Эрдэм шинжилгээний бичиг*, 45, 12-17.
Нарантуяа, Ш. (2021). *Дүрслэх үгийн тайлбар толь*. Улаанбаатар.
МУБИС. (2020). *Орчин цагийн монгол хэл I*. Улаанбаатар: Бит пресс.

- МУБИС. (2020). *Орчин цагийн монгол хэл II*. Улаанбаатар: Бит пресс.
- Өнөрбаян, Ц. (2000). *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс*. Улаанбаатар:
- 게이 람스테트. (1952). *알타이어 형태론 개설*. 서울.156-220 페이지.
- 국어 사전. (2006). *국어 사전 제6 판*, 민중 서림.
- 이기원. (2007). *한국어의 의성어, 의태어*. 서울.
- 채완. (2003). *한국어의 의성어와 의태어*. 서울 대학교 출판부. 45-70 페이지.
- 정경일 등. (2000). *한국어의 탐구와 이해*. 서울. 56-60 페이지.
- 한몽 사전. (2006). *한몽 사전*. 몽골국립대학교 한국어학과.